

## ЭРДЭНЭ РЕСУРС САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЛИЙГ ТАНИЛЦУУЛЛАА

### Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот  
2024.12.10

**Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN)** ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь зээлийн гэрээ байгуулсан тухай мэдээлэхэд таатай байна. Монголиан Майнинг Корпорэйшн ("ММС")-тэй хамтран хөгжүүлж буй өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Баянхөндий Алтны Төсөл ("Баянхөндий" эсвэл "БХ" эсвэл "Төсөл")-ийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, ашиглалтад оруулах зорилгоор Эрдэнэ Монгол ХХК ("ЭМ") нь Худалдаа Хөгжлийн Банк ("ХХБ")-тай хамтран 50 сая ам.доллар хүртэл зээлийн гэрээг амжилттай байгууллаа. Мөн компанийн варрант хэрэгжүүлж буй тухай мэдээллийг хүргэж байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "Бид Монголын тэргүүлэх санхүүгийн байгууллагуудын нэг Худалдаа Хөгжлийн Банкнаас зээл авч байгаадаа баяртай байна. Энэхүү зээлийг Баянхөндий алтны төслийн олборлолтын бэлтгэл ажил болон үйлдвэрийг ашиглалтад оруулахад зарцуулах бөгөөд бид 2025 оны дунд үе гэхэд анхны алтыг үйлдвэрлэн, гуравдугаар улиралд алтны олборлолтыг тогтворжуулах зорилготой ажиллаж байна. Энэхүү санхүүжилт нь үйлдвэрлэлийн эхний үе шатанд шаардлагатай санхүүгийн хэрэгцээг хангана. Бид одоогоор боловсруулах үйлдвэрийн барилгыг дээвэрлэх, битүүлэх, 2025 оны 1-р улиралд механик, цахилгааны ажлуудыг дуусгахаас өмнө чухал ач холбогдол бүхий дэд бүтцийн барилга байгууламжуудыг эцэслэх ажлуудыг гүйцэтгэж байна. Мөн эхний жилийн олборлолтыг дэмжих 13,700 метрийн хүдрийн хяналтын өрөмдлөгийг гүйцэтгэн, нэгдсэн хаягдлын сангийн байгууламжийн эхний үе шатны бүтээн байгуулалтыг энэ сард эцэслэх хуваарьтай байгаа ба 2025 оны хоёрдугаар улиралд алт олборлолтыг эхлүүлэх боломжтой.

Тэрээр үргэлжлүүлэн: "Азийн хамгийн том хөгжүүлэлт хийгдээгүй молибденийн ордуудын нэг Зуун Мод төслийг хөгжүүлэхэд зарцуулагдах 5 сая канад долларын варрантыг хэрэгжүүлэхээр болсон ба үүнд Эрдэнэ Ресурсийн томоохон хөрөнгө оруулагч Эрик Спротт оролцож байна."

### Баянхөндий төслийн эргэлтийн хөрөнгийн зээл

Эрдэнэ Монгол ХХК нь Баянхөндий алтны төслийг ашиглалтад оруулах эргэлтийн хөрөнгийн хүрээнд Худалдаа Хөгжлийн Банктай зээлийн гэрээ байгууллаа. 50 сая ам.доллар хүртэл хэмжээтэй энэхүү зээл нь 24 сарын хугацаатай бөгөөд зээлийн сүүлийн 6 сарын хугацаанд тэнцүү 6 удаагийн төлөлтөөр эргэн төлөгдөх нөхцөлтэй. Зээлийн хүү жилийн 13.3% байх ба Баянхөндий төслийн боловсруулах үйлдвэрийн хөрөнгөөр баталгаажсан. Эрдэнэ Ресурс болон ММС-ийн стратегийн түншлэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 2024 оны 1 сарын 29-нд гарсан [хэвлэлийн мэдээ](#)нээс үзнэ үү.

### 2024 оны 12 сард хэрэгжүүлж буй варрант

Эрдэнэ Ресурс нь 2024 оны 12 сарын 21-ний өдөр хугацаа нь дуусах компанийн энгийн хувьцааг худалдан авах эрх бүхий варрантууд хэрэгжүүлэх амлалтыг хүлээн авсан ба үүнд Эрик Спроттын өмчлөлийн 2176423 Ontario компанийн эзэмшдэг варрантууд багтаж байна.

Энэхүү амлалтын хүрээнд Компани нь 6,689,697 энгийн хувьцаа гаргасан ба 2024 оны 12 сарын 21-ний дотор 6,370,755 энгийн хувьцааг нэмж гаргана. Варрантыг хэрэгжүүлснээр \$5,224,181 долларын орлогыг төвлөрүүлэх ба үүнийг Эрдэнэ Монгол ХХК-ийн сонирхлын бүсээс гадуурх төслүүдийг урагшлуулах, тухайлбал компанийн Зуун Мод молибден-зэсийн төсөл болон ерөнхий үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулна. 2022 оны 12 сарын 22-нд танилцуулсан Эрик Спроттын оролцсон хаалттай хөрөнгө оруулалтын тухай [хэвлэлийн мэдээ](#)тэй танилцана уу.

### Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 1 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийн хувь эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Эрдсийн Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

*Орчуулга: Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө*

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

Холбоо барих

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал  
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>